

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
АЖЛЫН ХЭСГИЙН ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар, Улсын Их Хурал 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 99 дүгээр захирамжаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Г.Ганболд, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 8, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсэгт “Хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа эрхлэх асуудал нь хамаарах Байнгын хороонд танилцуулна.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын “d.parliament.mn” цахим системд иргэдээс ирүүлсэн 52 санал, ажлын хэсгийн гишүүн А.Адъяасүрэн, Ж.Батжаргал, Т.Доржханд, С.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг нараас ирүүлсэн 63 санал, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн саналууд болон 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж, улс төрийн 30 намын төлөөлөл оролцсон хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг үндэслэн ажлын хэсэг дараах саналыг гаргаж, Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар 44, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр 18 нийт 62 зарчмын зөрүүтэй саналын томъёолол, мөн найруулгын 2 саналын томъёолол бэлтгэлээ.

Түүнчлэн хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу эцсийн хэлэлцүүлгийн шатанд шинээр боловсруулах шаардлагатай байна.

Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулах харилцааг Улсын дээд шүүхэд

шилжүүлэх саналтай уялдуулан дээрх хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах санал боловсруулан танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхааралд тавьсанд баярлалаа.

---oOo---